



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/131

Хажуу шинэ ус

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх  
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 5.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. ITRF-97 солбицлын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа болон Хаягжуулалтын тухай хуулийн дагуу шинэ хаяг авсан 9 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг газрын даамал (Б.Хорол)-д үүрэг болгосугай.

Гурав. Газрын талбайн хэмжээний өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг улсын бүртгэлийн мэргэжилтэн (Б.Цэрэнням)-д үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн №21 тоот захирамжийн хавсралт хэсгийн 5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ө. МӨНХ-АМГАЛАН

482201131



Засаг даргын 2022 оны 4 дугаар сарын 22 өдрийн 1137 тоот захирамжийн 1 дүгээр хавсралт

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан иргэд

№	Овог нэр	Регистрийн дугаар	Зориулалт	Газрын			Шинэ хаяг
				Өмнөх газрын Хэмжээ /м2/	Өөрчлөгдсөн газрын Хэмжээ /м2/	Үнэлгээ /мян төгрөг/	
1	Б. Эрдэнэбулган	3В65042519	Гэр бүлийн хэрэгцээнд	750	953	620480	Нарлаг Дэнж 6-4 ТООТ Ерлөг-11 1108 тоот